



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 5/05

Мөрөн

Унаа хоолны нөхөн олговрыг
нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7 дахь заалт, Засгийн Газрын 2019 оны "Журам батлах тухай" 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх олговор олгох журам" -ын 8 дугаар хэсгийн 8.4, Эрүүл мэндийн төвийн хөдөлмөрийн дотоод журмын 10 дугаар зүйлийн 10.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн төвийн ажилчдын унаа, хоолны нөхөн олговрыг өдрийн 15000 /арван таван мянган/ төгрөгөөр тооцон нэмэгдүүлсүгэй.

2. Ажилчдын унаа хоолны нөхөн олговрыг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогч (Х.Тунгалагзул)-д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ



Б.ГАНДОЛГОР